

ЭРДМИЙН НАРАН ЭРГҮҮЛЭГ

(Сэтгүүлчийн тэмдэглэл)

*Ч.Содномдорж****Хайсандай хаана явна вэ?**

Ийм нэртэй захиаг ШУА, “Улаанбаатар” их сургуулийн эрдэмтэн багш бүсгүйчүүдээс Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор, профессор Лувсангийн Хайсандайн 70 насны ойн эрдмийн баярын үеэр ирүүлжээ. Хүн арддаа, тэр дундаа хүүхнүүдэд үгүйлэгдэхийн гайхамшигийг эрдэмтэн Хайсандай ийнхүү үлгэр жишээчээр үзүүлж чадлаа. Тэрбээр нэг муу эр хүний оронцог маягийн бол эрдэмтэн хүүхнүүд яалаа гэж үгүйлэх юм бэ? Түүний 70 насны ойн эрдмийн баяр ГХЯ-ны хурлын танхимд болж байлаа. Монгол Улсын мөрөн дээрээ олгойтой бус толгойтой болгон энэ эрдмийн баярт хуран цуглажээ. “Хайсандай ах бид хоёр нэг нутаг усны хоёр. Бооржийн голын унага гэсэн үг. Намайг цэргийн дипломатын академи төгсөж, ардын цэргийн бригадын генерал болоход Хайсандай ахын ач тусыг үнэлж баршгүй. Яагаад гэвэл намайг жаахан хүү байхад манай аав, ээж хоёр чи Хайсандай шиг дандаа онцсайн суралц. Хайсандай шиг алтан Москва хотод их сургуульд явж суралц. Хайсандай шиг орос, англи, испани зэрэг олон гадаад хэл үзэж, судалж, төрөлх хэл шигээ эзэмш. Хэлтэй бол хөлтэй гэж зааж сургадаг байлаа. Намайг сурагч байхад Хайсандай ах Москва хотын олон улсын харилцааны дээд сургуульд оюутан байжээ. Амралтаараа Мөст сумандаа бөөн жинс болсон гоё залуу ирдэг байлаа. Нээрээн би Хайсандай ах шиг гадаадад их сургуульд явна гэж зорьсоор байгаад цэргийн олон улсын харилцааны мэргэжил эзэмшиж билээ” гэж Стратеги судлалын хүрээлэнгийн захирал, профессор Б.Даваадорж ярьж байсан. Энэ эрдмийн баярын үеэр Улаанбаатар их сургуулийн ректор, доктор, профессор С.Байгальсайхан “Хайсандай хаана явна вэ?” гэсэн хаягтай, эрдэмтэн бүсгүйчүүдийн чин сэтгэлийн захиаг Л.Хайсандай абугайд гардуулж билээ. Хайсандай хаана явах вэ? Хажууд чинь, дэргэд чинь явна, Хүүхнүүдээ. Тэрбээр дажгүй, далан нас сүүдрийг зооглосон ч дөнгөж тавь шүргэж байгаа юм шиг ануухан, залуухан гялалзаж, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирлаар ажиллаж, хөдөлмөрлөсөөр явна.

Хайсандай абугайн аав ерөөл, магтаал хайлдаг, эм дом хийдэг, зурхайн ухаанд шаггүй, хүний мөс жудгаар нутаг усандаа үлгэр жишээ болсон жижигхэн шар өвгөн байлаа. Түүнийг Мөст нутгийнхан нь “Тооку Лувсан” гэлцэнэ.

Энэ ухаалаг, овсгоолог, тэр үедээ л зах зээлч шар өвгөн мал маллаж, арвай буудай тарьж ургуулахын зэрэгцээ захчин хүн мөртлөө торгууд ардын өмсгөл “Тооку” хэмээх гутлыг хачин уран, гоё, бөх,

* Ч.Содномдорж - сэтгүүлч, зохиолч

дөрөө даах эдэлгээтэй оёж хатган гэрээр үйлдвэрлэж, нутгийн хүн арддаа зарж борлуулдаг байжээ.

Тийнхүү Лувсан гуайн гэр айл-үйлдвэр, өөрөө үйлдвэрлэгч, ажилсаг, хөдөлмөрч нэгэн байжээ. Өөрийн нэрийн бүтээгдэхүүнээрээ алдаршиж, ард түмнээсээ “Тооку” хэмээх алдар нэрийг хүртсэн бол хүү Хайсандай нь Монголын шинжлэх ухаанд 40-өөд жил зүтгэж, эрж хайж, бүтээж, туурвиж, хэн дуртай аавын хүү хүсэвч болзол, шалгуурыг нь давж бардаггүй академич хэмээх алдар цолыг хүртсэн байна. “Хайсандай ах бид хоёр нэг аймаг, нэг сум, нэг баг, нэг довын хоёр. Шинжлэх ухааны академид 40 шахам жил ажиллахдаа сүүлийн арван жилд нь олон улс судлалын хүрээлэнгийн захирлын албыг хашиж байна. Нэг байгууллагад, тэгээд цалин пүнлүү багатай ажилд ийм олон жил хөдөлмөрлөнө гэдэг ховор үзэгдэл мөн. Сонгосон мэргэжил, эрдэм судлалдаа үйлийн үргүй үнэнчийн яруу тод үлгэр жишээ энэ мөн үү? Мөн байлгүй яах вэ Олон улс судлалын чиглэлээр 160 гаруй бүтээл туурвисан нэртэй эрдэмтэн Л.Хайсандай ахыг “Жижиг биетэй ч том эрдэмтэн, намхан нуруутай ч ланжгар менежер” гэж хэлэхээс өөр үг олдохгүй байна гэж Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирал, доктор Б.Цогоо хүүрнэж суусан сан.

Дэлхийд данстай, монголд морьтой

ШУА-ийн Ерөнхийлөгч Б.Энхтүвшин “Хайсандай бол дэлхийд танигдсан том эрдэмтэн” гэж хэлсэн юм. Би түүнтэй уулзаж, Хайсандай аругайн тухай хөөрөг зөрүүлэх зуурт хэдэн сайхан үг сольж амжсан билээ.

- Хайсандай гуайн толгойлдог олон улсын хүрээлэн хаанаас эхтэй, хэдийд үүсч хөгжсөн юм бэ?

- Анх ШУА-ийн Ази-Африкийн хэлтэс нэртэй одоогоос 40 жилийн өмнө үүсч, тулгын чулуугаа тулж байжээ. Эндээс олон улс судлалын хүрээлэн өрх тусгаарлаж, шинэ салбар болон өргөжин тэлсэн. Тус хүрээлэнг дэлхийд данстай эрдэмтэн Б.Ширэндэв, Ш.Бира, Ч.Далай, Н.Ишжамц, Л.Жамсран, Г.Сүхбаатар нар толгойлж явсан бахархал буй. Тэднийг нэр төртэй залгамжлагчдын нэг бол Гүүш овогт Лувсангийн Хайсандай яахын аргагүй мөн. Тэгээд ч Дорно дахины жаахан Хайсандай, дэлхийд танигдсан нэртэй эрдэмтэн; Олон улс судлалын Хайсандай, орчлонд танигдсан “эрдмийн жинчин” гэж түүний төрсөн нутаг Ховд аймгийн Мөст сумын нэг ангийн анд нөхөд нь төдийгүй ард түмэн бултаараа ярилцдаг юм билээ.

- Хайсандай гуай ажил хөдөлмөрийн гараагаа хаанаас эхэлсэн юм бол? Ямар ямар ажил, алба хашиж явсан эр вэ?

- Тэрбээр 1965 онд Москва хотын олон улсын харилцааны дээд сургуулийг улаан дипломтой төгсөж, НҮБ-ын албан ёсны гол хэл орос, испани хэл эзэмшсэн, олон улсын харилцааны түүхч, орчуулагч болжээ. Монгол Улсыг гадаадад, дэлхийг эх орондоо таниулах гэрэлт цонх

болсон МОНЦАМЭ агентлагаас ажил хөдөлмөрийн гараагаа эхэлжээ. Удахгүй албан тушаал дэвшиж, Монголын Залуучуудын Эвлэлийн Төв Хороонд МОХ-ны орлогч дарга, гадаад харилцааны хэлтсийн эрхлэгчээр 1966-1974 онд ажиллажээ. Тэрбээр дэлхийн залуучууд оюутны их наадам, чуулга уулзалтуудад улс орноо төлөөлөн оролцохын хамт олон улсын залуу үеийнхний орчин үеийн хөдөлгөөн, энх тайван, хөгжил дэвшил, улс түмний найрамдал, хамтын ажиллагааны талаар хоёр ном, 60 гаруй өгүүлэл, нийтлэл, тэмдэглэл бичиж сонин сэтгүүлд нийтлүүлсэн байна. Тэрбээр НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга У Тан, Кубын Фидель Кастро, Че Гевара, Алжирын Бен Белла, Чилийн Сальвадар Аленда нарын зэрэг дэлхийд данстай хүмүүстэй улаан нүүр учирч, үг хэлээ ололцож, үйл хэргээ бүтээж явсан бие багатай ч бэлчээр томтой эр хүн шүү цаадах чинь. Энэ бүхэн нь Дорнодахины судлалын хүрээлэнгийн хөрөнгөтөн ба хөгжиж буй орнуудын тасагт эрдэм шинжилгээний ажилтан болох суурь дэвсгэр болжээ.

- Тэрбээр олон улсын харилцааг насан турш судалсан мундаг эрдэмтэн юмаа даа? Түүний эрдмийн тамир тэнхээг хэрхэн тодорхойлох вэ?

- Л.Хайсандай 1980 онд “Монгол ба хөгжиж байгаа орнуудын харилцаа /1955-1980/” сэдвээр дэд эрдэмтний зэрэг амжилттай хамгаалсан юм. Энэ нь Монголын гадаад харилцаа, хөгжиж буй орон судлалын тухайд манайдаа анхны бөгөөд дорвилог бүтээлийн нэг яах аргагүй мөн. Тухайн жилдээ “Монгол Улс ба хөгжиж байгаа орнууд /1955-1980/” хэмээх орос хэлээр хэвлүүлсэн нэгэн сэдэвт эрдмийн бүтээлдээ зохиогч Монгол Улс Ази-Африкийн шинэ тулгар чөлөөлөгдсөн орнуудыг тухай бүр хүлээн зөвшөөрч, тэдгээртэй нөхөрсөг харилцаа тогтоож ирсэн үйл явцыг тухайн цаг үетэй нь нягт уялдуулан онцлог шинж, чиг хандлагыг анх түрүүн эрдэм шинжилгээний үүднээс тоймлон үзжээ. Л.Хайсандайн бүтээлд “Монгол Улсын тэр үед шинээр тусгаар тогтносон улс орны тухайд баримталсан бодлого, байр суурь нь өөрөө дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдөх үйл явцыг эрчимтэй өрнүүлж, улмаар НҮБ-ын бүрэн эрхт гишүүнээр элсэн орох, олон улсын нэр хүндээ өсгөн бэхжүүлэхэд ихээхэн тус дөхөм болсон гэсэн бодитой шинэлэг дүгнэлт хийжээ.

1960-аад оны үеэс эхлэн Монгол Улсыг феодализмаас капиталист нийгмийг алгасан социализмд дэвшин орсон “анхны социалист” орон хэмээн тунхагласан үзэл номлол, суртал үнэмлэхүй ноёрхож байсан чухамхүү тэр үед шинэ тутам хөгжиж байгаа орон судлалаар хийсэн судалгаандаа тулгуурлан, “Монгол Улс бол хөгжиж байгаа орон мөн” гэсэн шинжлэх ухааны үндэслэл бүхий шинэ томъёоллыг анх олон улсын харилцаа судлаач Л.Хайсандай дэвшүүлэн гаргаж, манай улс НҮБ-ын Ази-Африкийн бүлэг, хөгжиж байгаа орнуудыг нэгтгэсэн “77-ийн бүлэг”, улмаар эвсэлд үл нэгдэх

хөдөлгөөнд элсэн орж, хамтран ажиллах явдал олон талын ач холбогдолтой гэсэн тодорхой санаа дэвшүүлж, төр, засгийн бодлого, шийдвэрт бүүр тэр үед тусгуулж чалсанаар өнөөдөр бүрэн биелэлээ олсон байна. Энэ нь эрдэмтэн Л.Хайсандайн эрдэм шинжилгээний ажлын чухал үр дүн мөн” гэж түүхийн шинжлэх ухааны доктор Ш.Сандаг өндөр үнэлжээ.

- Хайсандай гуайн - эрдэм судлалын бүтээлийг гадаад дотоодын нэрт эрдэмтэд айхтар өндрөөр үнэлдэг юмаа даа?

- Тэрээр 1999 онд “ Монгол Улсын үндэсний эрх ашиг ба гадаад бодлого: онол практикийн асуудал” сэдвээр шинжлэх ухааны /Sc.D/ докторын зэрэг хамгаалсан байна. Л.Хайсандайн доктор /Ph.D/, шинжлэх ухааны докторын /Sc.D/ ажлыг хоёуланг нь Монголын шинжлэх ухааны ноён сүмбэр оргилын нэг, академич Б.Ширэндэв агсан удирдсан нь түүний оюуны бяр тэнхээг үнэлсэн хэрэг юм.

Лувсангийн Хайсандайн “Монгол Улсын үндэсний эрх ашиг ба гадаад бодлого: онол, практикийн асуудал” бүтээл нь Монгол Улсад энэ чиглэлээр судалж туурвисан анхны томоохон бүтээл болсны хувьд хөгжлийн стратеги, түүх олон улс судлаачдын анхаарлыг зүй ёсоор татдаг юм. Эл бүтээлийн үнэ цэнийг олон эрдэмтэн онцлон тэмдэглэсний дотроос түүхийн шинжлэх ухааны доктор Н.Дангаасүрэн: “Монгол Улсын гадаад харилцааг үндэсний эрх ашгийн үүднээс онол, арга зүйн шинэ баримтлал, чиглэлээр судалсанд Л.Хайсандайн энэ бүтээлийн шинэлэг тал тодорно. Энэ шинэлэг тал бол улс төр судлал, түүх судлалыг уялдуулан Монгол Улсын үндэсний эрх ашгийн түүхэн үйл явцыг үнэлж цэгнэхэд оршино. Монгол Улсын үндэсний эрх ашигт багтах харилцан уялдсан асуудлыг онолын хувьд гаргаж тавьсан нь маш сонирхолтой болжээ” хэмээн үнэлэлт, дүгнэлт өгчээ.

- Монгол Улсын үндэсний эрх ашиг, тусгаар тогтнол, аюулгүй байдлыг дэлхийн даяаршлын үед яаж, хэрхэн хадгалж бэхжүүлэх нь Хайсандай гавъяатын эрдэм судлалын ажлын амин гол судас юм уу даа?

- Яг тийм шүү. Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, хөгжлийн гарц бол түүний зохиол бүтээлийн мөн чанар байдаг. Тэрбээр 1999 онд академич Б.Балдоо, доктор, профессор С.Дамдинсүрэнтэй хамтран “Монголын тусгаар тогтнол ба Орос, Хятадын хүчин зүйлс” хэмээх зохиол бичсэн нь 2006 онд Монголын 20 дугаар зууны шилдэг бүтээл болон шалгарч, “Монголын ШУ-ны шилдэг бүтээлийн дээжис-99” ботид багтах эрх авчээ.

- Хэрэв та алгуурлахгүйгээр түүний бүтээл, туурвилын тоо хэмжээг багцаалж гаргах юм бол ямар байх бол?

- Эрдэмтэн, судлаач Л.Хайсандайн “Эрдмийн бүтээлийн товчоон”-оос харахад эрдэм шинжилгээний ном, зохиол 12, эрдэм шинжилгээний хамтын бүтээл 8, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл

160 гаруйг бүтээн туурьвижээ. Үүнээс 40 гаруй бүтээл нь ОХУ, БНХАУ, БНСУ, Тайвань, Турк, Энэтхэг, Япон зэрэг улс гүрэнд орос, хятад, англи, испани, солонгос, турк хэлээр хэвлэгдсэн хийгээд мөн 30-аад ном зохиолыг хянан тохиолдуулан хэвлүүлсэн байна. Энэ бүхнээс харахад тэрбээр хэр өргөн цар хүрээтэй, дэлхийд данстай эрдэмтэн болохын бодит баталгаа юм.

- Хайсандай абугай зүгээр нэг эрдэмтэн судлаач төдийгүй, авъяаслаг удирдагч, овсгоолог менежер, сайн дарга юм биш үү?

- Таны санал минийхтэй нэгэн уулзварт нийлж байна. Хайсандай эрдмийн ажилд ямагт дэвшиж, өөдөлж явсан замналтай. Дорнодахины хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтнаас олон улс судлалын хүрээлэнгийн захирал хүртэл дэвшиж ажилласан. Одоогоос 10 жилийн өмнө түүний нэрийг Академич Ч.Далай гурван гол үндэслэлээр олон улс судлалын хүрээлэнгийн захирлаар томилон ажиллуулах санал дэвшүүлж байсныг би мартаагүй байна.

- Ямар гол үндэслэл байсан бэ? Хэрэв нууц биш бол та хэлж болохсон болов уу?

- 1. Хайсандай бол олон улсын харилцаа судлалын унаган мэргэжилтэн хүн. 2. Тэр бол аугаа их эрдэмтэн Базарын Ширэндэвийн гарын хайртай шавь мөн. 3. Хайсандай бол зөвхөн дэлхийд данстай эрдэмтэн төдийгүй шинжлэх ухааны сайн менежер, овсгоотой удирдагч мөн. Ийм гурван гол үндэслэлийг академич Ч.Далай бидэнд хэлж байсныг бид харгалзан үзэж, Хайсандай докторыг олон улс судлалын хүрээлэнгийн захирлаар томилон ажиллуулж байсан минь алдаагүй, харин ч айхтар оновчтой шийдвэр байсныг сүүлийн 10 жилийн ажил үйлс нь батлан харуулж байна.

- Том эрдэмтний нэг шалгуур бол хэд хэчнээн шавьтай вэ? Шавь нараас нь хэд, хэчнээн нь эрдмийн зэрэг цол хүртсэн бэ? гэдэг асуудал байнга хөндөгдөж яригддаг даа. Хайсандай абугайн тухайд гэвэл...

- Хоёрхон тасагтай, хориодхон ажилтантай хүрээлэнг Хайсандай доктор хүлээж аваад орон байргүй байсныг орон байртай болгож, Орос, Хятад судлалын гэсэн хоёр үндсэн салбар, Япон, Америк, Солонгос ба Зүүн Ази, Европ, Төв Ази судлал гэсэн 5 сектортой, нийт 40-өөд эрдэм шинжилгээний ажилтантай, үүнээс ШУ-ны доктор 4, боловсролын доктор 12, магистр 11, ЭША 12-той болгосон хийгээд нийт ажиллагсадын 70 шахам хувь нь мэргэжлийн залуу хүмүүс ажиллаж байгаа юм. Зөвхөн энэ хугацаанд шавь нараасаа ШУ-ны доктор 4, боловсролын доктор 4-ийг төрүүлсэн төдийгүй гадаадын нэрт дипломатуудад “Хүндэт доктор”-ын өргөмжлөл, эрдэм судлалын профессор цолыг санаачлан буй болгож, бараг 40 гаруй хүмүүст олгосон байна.

Эрдмийн хур

Хайсандай ахын эрдэм шинжилгээ, судалгааны өгүүллэгүүдийг уншиж, тархиа нээж, задалж, зүрх сэтгэлээсээ татагдаж, эрдэмтэн хүн ийм л байдаг юм байна гэж биширч шүтэж явдаг олон залуу эрдэмтний нэг нь би билээ. Ямарч хэцүү бэрх цаг үед үндэсний эрх ашиг, тусгаар тогтнол, аюулгүй байдал гэсэн тулгын гурван чулуу шиг шадар, ихэр гурван асуудал бол Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор, профессор Л.Хайсандайгийн олон улсын харилцаа судлалын амин цөм нь, гол сүнс нь билээ. 1990-ээд онд би түүний эрдэм, номын унаган шавь болсондоо ямагт бахархаж явдаг юм. Эрдэмтэн багш минь Монголын ард түмний чанх дээрээс хөх мөнх тэнгэр шиг эрдэм номын ариун дагшин хур буулгаж яваарай гэж залуу эрдэмтэн Ж.Бор уулга алдлаа.

...Гадаад харилцааны гарамгай гүн мэдрэмжтэй эрдэмтэн гэвэл та мөнөөс мөн. Та Хятад, Монголын харилцаанд юугаар ч сольшгүй их хөрөнгө оруулалт хийжээ гэж БНХАУ-д суугаа Монгол Улсын ЭСЯ-ны элчин зөвлөх, түүний шавь, түүхийн шинжлэх ухааны доктор Ц.Батбаяр Хайсандай аругайн 70 насны эрдмийн баярын үеэр цахилгаан ирүүлснийг олон нийтэд уншиж сонсголоо. Доктор Л.Хайсандайн эрдмийн хур бороо нь яг л Алтайн хөх салхины нөөлөгт хөөгдсөн юм шиг азнаж азнаж байгаад гэнэт асгарч ордог юм сан уу.

Оюун сэтгэлгээний нь давалгаан үе үехэн үерлэхийг нь би адилтгаж байгаа минь энэ. Энх тайван, найрамдал, хамтын ажиллагааны тухайд бол эрхэм гавьяат яг л Алтайн өндөр уул шиг ноён нуруутай хүн гэдгийг дэлхийн энх тайван, найрамдлын байгууллагууд андахгүй мэднэ. Энх тайван, найрамдлын байгууллагуудын хувьд бол би өөрийгөө партизан гэж бодож явдаг юм.

Надаас өмнө аль эрт партизан болсон хүн бол Лувсангийн Хайсандай мөн гэж Монголын энх тайван, найрамдлын байгууллагуудын холбооны ерөнхийлөгч, Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, соёлын гавьяат зүтгэлтэн Д.Цахилгаан түүний тухай элэгтэй, халуун дулаан, сайхан үг хэлж билээ. Академич Ж.Болдбаатар: "...1960 онд би МУИС-ийн оюутан байлаа. Тэр үед Монголын оюутны холбооны даргаар зассан шагай шиг хөөрхөн хархүү ажиллаж байсан нь энэ Л.Хайсандай байсан юм. Бид дарга Хайсандай шиг гоё, ганган хувцаслаж, Хайсандай дарга шиг гялалзтал эрдэм ном сурч, сайхан мэргэжил эзэмшихийн төлөө байдаг л цаг, заваараа хичээдэг сэн. Тэрбээр эрдмийн бөөрөнд мөн л зассан шагай шиг үлдэж, эрдмийн хур буулгасаар бараг 40 жилийг өнгөрөөжээ. Шагайг олон арван жил тоглохоор улам цэмцгэр, хотгор, гүдгэргүй, тэгшхэн болдог. Эрдэмтэн Л.Хайсандайн эрдэм судлалын бүтээлүүд яг л зассан шагай шиг өө согоггүй бүтээлүүд байдаг билээ" гэж тэрбээр айлдлаа.

“Илжгэн халхын их хүргэн”

Түүхч, эрдэмтэн Ц.Ишдорж тэр үеэр ийн ам алдлаа. Тэрбээр Монгол эх орон минь олон сайн хүргэнтэй. Жишээлбэл: Төмөрхаан, Рерих байна. Дэлхийд данстай алдарт зураач Рерих амьдралдаа 7000 гаруй уран зураг зурсан билээ. Тэдгээрийн 500 гаруй нь их эзэн Чингис хааны хатад, гүнж, агь, бусад өрлөг жанжин, үр садын хөрөг, зураг урлан байлаа. Манай илжгэн халх овгийнхон эрдэмтэн, профессор, Л.Хайсандайг хэнээс ч дутахгүй сайн хүргэн гэж хүндэтгэн ам сайтай, элэг нэгтэй байдаг юм. Илжгэн халхынхан бол Увс аймгийн Зүүнхангай, Өндөрхангай сумын ариун дагшин халх удам угсаатан юм. Дэлхийд бүтээл туурвилаараа танигдсан эрдэмтэн Л.Хайсандай энэ нутаг усны уугуул Орсоогийн Цацрал гэдэг бүсгүйтэй насны залуу, цусны исгэлэнд ханилан сууж, үгүй дутуугаа гүйцээж, үр хүүхдээ өсгөж, жаргал зовлон хурсан амьдралын алаг заяа тавилан, уул даваа гүвээний өндрийг ч давж, ус мөрөн, далайн өргөн, гүнийг ч гаталж, урт замыг туулжээ. Хадмынхандаа төдийгүй хадмын нутаг усныхны хайр хүндэтгэлийг хүлээнэ гэдэг хүргэн хүнд олдошгүй эрхэм хувь заяа байдаг бус уу?

Академиц Г.Чулуунбаатар: Алтай нутгийн ах Л.Хайсандай бол ланжгар эрдэмтэн, шилдэг менежер хүн.

Эрдэмтэн хүний зоримог, шийдмэг зан араншинтай, улс хоорондын геополитикийн бодлогоор дагнан мэргэшсэн, олон улсын харилцааны аюулгүй байдлыг судлахад өөрийгөө залгай мөнгө шиг зарж үрсэн хүн бол манай Хайсандай ах. Та улам өндөр болоорой. Далан насанд эрт цагт даруулга хэрэгтэй байсан бол өдгөө үед зөвхөн дэлхийн дэвжээ хэрэгтэй болсон шүү гэж хошин өнгө аясаар үнэн үг хэллээ.

Нэг том эрдэмтэн түүний нэрийн утга учрыг тайлбарлахдаа “төвд санскрид хэлээр бол Хайсандай гэдэг чинь дээшээ харсан амсартай том тогоо, өөдөө зүглэсэн амтай том ай сав нутаг усны нэртэй дүйж байгаа юм гэж айлдлаа. Бас нэг лут эрдэмтэн түүхч тэр юул бол. Харин их эзэн Чингис хааны өрлөг нэгэн жанжныг Өгөөдэй, удам залгах унаган үр садыг нь Сүбээдэй гэдэг алдартай агуулгын хувьд ч хамаатан, хэлбэрийн хувьд ч садан байгаа биз дээ гэж онцлон дуугарлаа.

Үнэнийг хамгаалагч, худлыг хуйхлагч

Манай баруун Алтайнхан хурц шовх уулс шигээ цочмог зан араншинтай, жад сэлэм шиг дэндүү шулуун шударга үзэл бодолтой, аливаа юмс үзэгдлийг өөр өнцөг, ондоо талаас нь харж, хандаж, нягтлаж, шүүмжлэх дуртай ард түмэнсэн. Тиймээс ч Хайсандай ахын нутаг усанд есөн эрүү шүүлтийг алзахгүй давж, хонгоныхоо махыг урагдтал, чөмөгнийхөө ясыг цайтал, арван хошуу алгасан зарга шүүж үнэнийг олсон Алдаржавын хүү, ардын баатар Ард Аюуш төрсөн бус уу? Энэ цагаан цаасан дээр бичигдээгүй хууль, тунхаглан зарлаж

тамгалан дэглээгүй жам ёсыг Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, доктор, профессор Лувсангийн Хайсандай бас л тойрсонгүй. Хэд хэдэн эрдэмтэн түүний шулуун шударга зан араншинг сайшаах өнгөөр дэмжиж үг хэллээ. Харин нэг нь “Манай Хайсандай шинжлэх ухаанч голч үнэлэлт, дүгнэлт гаргаж чаддаг, дандаа л магтах биш бас шүүмжлэх талдаа явдаг хүн дээ” гэж үнэн сэтгэлээ өгсөн юм.

Түүхийн шинжлэх ухаан бол төвөгтэй шинжлэх ухаан мөн үү гэвэл мөнөөсөө мөн. Түүхийн шинжлэх ухаан цаг үеийн бусармаг давалгаанаас болоод эдийн засаг шиг эрс хямардаг уу гэвэл хямардаг. Жишээлбэл 1990-ээд онд Монголын балтаар цавцивч баларшгүй, дөшөөр давтавч арилшгүй үнэн түүх цадигийг өнгөлөн далдалсан ардчиллын гэх хутган үймүүлэх, холион бантан зуурах маягаар гуйвуулах эрс мулгуу хандлага ширүүссэнийг ард түмэн минь андахгүй байхаа. Хэзээ ч түүх цадигийг жадлан сэлэмдэж, хутгалан шөвөглөж болдоггүй билээ.

Энэ хэцүү бэрх цаг үед олон улсын нэртэй түүхч Л.Хайсандай түүхийн үнэнийг хамгаалах үйл хэрэгт эрдэмтэн түүхч хүний хариуцлагаа гүнээ ухамсарлан үлгэр жишээ үзүүлэн, зүйрлэж хэлбэл Хятадын цагаан хэрэм, цайз мэт хатуу байр сууринаас хамгаалан тэмцэж явсан. Түүхийн үнэнд үнэнч үлдсэн, ер бусын хүмүүнлэг, цогтой тэмцэгч Л.Хайсандай докторт далан насны нь ойг тохиолдуулан, Монгол Улсын ба хөдөлмөрийн баатар, маршал Ю.Цэдэнбалын нэрэмжит Академийн эрхэм дээд шагнал болох “Ю.Цэдэнбал одон”-гоор түүнийг шагнасныг миний бие гардуулахад баяртай байна гэж тус Академийн ерөнхийлөгч, түүхч эрдэмтэн, доктор Н.Жамбалсүрэн сэтгэл догдлон өгүүлэн гардуулж өглөө.

Базарын Ширэндэвийн шаггүй шавь

Монголын түүхийн шинжлэх ухааны сүмбэр оргилын нэгэн Академич Б.Ширэндэв Хайсандай хүүг цэлмэг залуу наснаас нь ихэд тоож, үнэлдэг байжээ. Хайсандай ах мөн чиг эрдэмтэй чиг, элдэвтэй чиг, их гарын хархүү байсан байгаа биз. Ширэндэв аругай баргийн хүнийг тоож, тойлж явах хүн бишээ! Өөрийн гэрээс холдмооргүй, хүлгийн нуруунаас салмааргүй тийм идэр залуу насандаа түүхийн шинжлэх ухааны “Хаан”-д тоогдож, баруун гарын шавь нь болох нарт хорвоод олошгүй нандин сайхан хувь тавилан гагцхүү Хайсандай хархүүд заяажээ.

Манай орны олон улс судлалд гарсан нэг шинэлэг зүйл бол доктор Л.Хайсандайн санаачилгаар монголын ба гадаадын нэртэй эрдэмтэд, дипломатуудад “Хүндэт доктор”-ын өргөмжлөл, судалгааны профессор цол олгож хүртээх дэг журмыг боловсруулж, тэр дагуу тухайн өргөмжлөлийг ёслол төгөлдөр гардуулан өгч, “судалгааны профессор” цолыг олгосоор иржээ. Тухайлбал “Хүндэт доктор”-ын өргөмжлөлийг Роберт Скалапино /АНУ/, Р.Рыбаков /ОХУ/,

Б.Мацуда /Япон/, Хуан Жакуй/БНХАУ/, Ж.Бейкер/АНУ/, М.Ханада /Япон/, П.Мета /Энэтхэг/ болон Монголын нэр алдартай хүмүүс Л.Түдэв, Б.Жаргалсайхан, Ш.Бира, Ц.Гомбосүрэн, С.Дамбадаржаа нарт гардуулсан бөгөөд “судалгааны профессор” эрдэмтэн судлаач Ц.Хандсүрэн, Ж.Энхсайхан, Д.Цахилгаан, Д.Билэгт, О.Нямдаваа, Н.Төмөрхүлэг, Н.Дугарсүрэн, Г.Төмөрчулуун, Г.Мэнд-Ооёо нарын зэрэг хүмүүст хүртээжээ. Тийнхүү эрдэмтэн Л.Хайсандай бол Монголын гадаад бодлого, олон улсын харилцааны түүхийг бичилцэж, өөрийн оронд Орос, Япон, Герман, Энэтхэг судлал гэсэн шинэ салбарыг үүсгэн хөгжүүлэхэд гар бие оролцож, удирдан зохион байгуулж, залгамж халаа шинэ залуу олон эрдэмтний эрдмийн ажлыг нь удирдаж хамгаалуулсан зэрэг нөр их хөдөлмөр зүтгэлийг нь үнэлж 2005 онд Монгол Улсын “Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн” цол хүртээсэн ба мөн “Алтан гадас” одон, Их Монгол Улсын 800 жилийн ой, НҮБ-ын 60 жилийн ойн зэрэг хүндэт медаль, “Эрдэм шинжилгээний тэргүүний ажилтан” цол, тэмдгийг тус тус олгожээ.

Түүнчлэн “Монголын Алтан ном”, “Монголын алдар гавьяатнууд” зэрэг нэвтэрхий толь бичгүүдэд түүний ажил үйлс, эрдмийн бүтээлийн тухай дуурсган бичиж нийтэлжээ. Эрдэмтэн Л.Хайсандайн эрдэм ном, алсын хараатай оюун ухааны эргүүлэг нь тэнгэрийн наран мэт зөв чиг зүгтэй том тойрог болон хязгаар хярхаггүй алсарч, үнэхээр эх орны хил хязгаарыг давж, олон улсын цар хүрээтэй болсныг хэлэхгүй байхын аргагүй.

*“МОНЦАМЭ мэдээ” сонин. 2010 оны
нэгдүгээр сарын 14. Пүрэв. №09(1866)*